



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Консерваторын 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/290/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул Аудит ХХК-ийн
захирал Ч.Мөнхтуяа
Утас: 99108763

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/359
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын Консерваторын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Консерваторын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 448,502.9 мянган төгрөгийн үнэ бүхий рояль бага гарын төгөлдөр хуурыг олон улсын уралдаан тэмцээн, тоглолт зохион байгуулахад зориулж балансаас баланст шилжүүлж өгсөн байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Монгол Улсын Консерваторын захирлын 2020 оны 125 дугаар тушаалаар батлан мөрдөж байгаа боловч шинээр гаргасан холбогдох хууль тогтоомж, заавар, журмын өөрчлөлтийг тусгаж шинэчлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	161,073,136.11	191,183,451.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,657,995.00	6,657,995.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,657,995.00	6,657,995.00
31210	Төгрөг	6,657,995.00	6,657,995.00
31211	Төрийн сангийн харилцах	6,657,995.00	6,657,995.00
33	АВЛАГА	3,366,000.00	11,202,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	11,202,000.00
33500	Бусад авлага	3,366,000.00	-
33510	Байгууллагаас авах авлага	3,366,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	151,049,141.11	173,323,456.35
35100	Түүхий эд материал	17,504,383.04	17,122,936.00
35110	Тусгай зориулалттай материал	16,285,394.00	16,285,394.00
35130	Эм боох материал	1,218,989.04	837,542.00
35400	Хангамжийн материал	133,544,758.07	156,200,520.35
35410	Бичиг хэргийн материал	2,800,000.00	1,500,100.00
35420	Аж ахуйн материал	66,709,843.07	61,767,843.07
35450	Барилгын засварын материал	1,394,950.00	726,000.00
35470	Бусад хангамжийн материал	62,639,965.00	92,206,577.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,514,011,427.24	10,765,395,406.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,514,011,427.24	10,765,395,406.89
39200	Биет хөрөнгө	9,681,294,777.50	9,933,410,257.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,503,526,410.85	9,503,526,410.85
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,081,289,490.39)	(1,219,326,446.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	47,400,000.00	47,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,608,333.45)	(24,358,333.47)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	2,396,115,619.52	2,863,741,260.72
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,449,212,271.68)	(1,504,792,717.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	568,401,557.23	530,225,748.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	(437,938,448.41)	(410,020,033.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	16,958,000.00	16,958,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,564,583.49)	(2,396,583.51)
39217	Ном	141,506,317.32	132,452,951.81
39300	Биет бус хөрөнгө	832,716,649.74	831,985,149.72
39301	Программ хангамж	15,930,000.00	15,930,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(8,255,750.26)	(8,987,250.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	825,042,400.00	825,042,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	10,675,084,563.35	10,956,578,858.24
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,675,084,563.35	10,956,578,858.24
51	Засгийн газрын хувь оролцоо	10,675,084,563.35	10,956,578,858.24
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,010,432,655.62	8,010,432,655.62
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	8,010,432,655.62	8,010,432,655.62
51200	Хуримтлагдсан үр дүн	(2,661,405,922.18)	(2,379,911,627.29)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,225,579,621.69)	(2,661,405,922.18)
51220	Тайлант үеийн үр дүн	(435,826,300.49)	281,494,294.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,326,057,829.91	5,326,057,829.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,675,084,563.35	10,956,578,858.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,568,602,843.55	6,956,865,871.77
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	733,071,878.55	1,047,570,387.77
120	Нийтлэг татварын бус орлого	714,416,098.55	586,062,497.77
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	700,277,424.80	569,560,165.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	671,263,724.80	549,645,115.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,013,700.00	19,915,050.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,706,000.00	10,347,937.49
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,432,673.75	6,154,395.28
122	Тусламжийн орлого	18,655,780.00	461,507,890.00
122001	Хандив тусламж /дотоод/	18,655,780.00	461,507,890.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,835,530,965.00	5,909,295,484.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,787,853,665.00	5,824,019,484.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,787,853,665.00	5,824,019,484.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,677,300.00	85,276,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,850,000.00	12,352,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,827,300.00	72,924,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,004,429,144.04	6,665,444,773.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,004,429,144.04	6,665,444,773.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,684,585,038.34	6,275,783,240.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,029,197,004.31	4,828,039,491.94
210101	Үндсэн цалин	2,861,370,236.76	3,398,266,081.55
210102	Нэмэгдэл	939,038,371.40	1,192,503,000.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	151,982,500.00	155,763,000.00
210104	Урамшуулал	76,805,896.15	81,507,409.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	492,665,248.50	594,051,612.35
210201	Тэтгэврийн даатгал	346,281,911.73	418,850,776.89
210202	Тэтгэмжийн даатгал	40,615,120.21	49,073,052.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	31,994,856.03	38,567,641.31
210204	Ажилгүйдлийн даатгал	6,589,669.03	7,842,146.90
210205	Эрүүл мэндийн даатгал	67,183,691.50	79,717,995.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	357,249,497.29	372,518,107.31
210301	Гэрэл, цахилгаан	63,095,552.00	75,903,470.57
210302	Түлш, халаалт	85,571,912.29	97,489,017.58
210303	Цэвэр, бохир ус	43,582,033.00	34,125,619.16
210304	Байрны түрээс	165,000,000.00	165,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	58,901,952.00	29,798,239.00
210401	Бичиг хэрэг	7,086,390.00	4,129,350.00

210402	Тээвэр, шатахуун	1,358,177.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,152,800.00	12,016,171.71
210404	Ном, хэвлэл	10,363,260.00	205,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,484,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,966,600.00	579,240.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	17,490,725.00	9,750,694.29
210408	Бараа материал акталсны зардал	-	3,117,783.00
2105	Нормативт зардал	63,490,659.96	58,992,097.04
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	713,559.96	1,070,897.04
210502	Хоол, хүнс	62,244,100.00	57,659,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	261,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,916,055.00	20,871,560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,287,000.00	4,229,000.00
210604	Урсгал засвар	13,629,055.00	16,642,560.00
2107	Томилолт, зочны зардал	-	180,000.00
210702	Дотоод албан томилолт	-	180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,764,119.00	120,789,738.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,697,071.00	83,615,490.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,500,000.00	20,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,548.00	154,048.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,387,500.00	16,520,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	568,400,502.28	250,542,394.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,031,600.00	4,967,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	61,148,472.75	11,553,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	492,220,429.53	234,021,244.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,844,105.70	389,661,533.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,597,468.00	295,113,284.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,086,450.00	71,411,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,787,618.00	223,702,284.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,723,400.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	204,246,637.70	94,548,249.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,263,087.70	94,548,249.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,983,550.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(435,826,300.49)	291,421,097.89
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	9,926,803.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	9,926,803.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(435,826,300.49)	281,494,294.89

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,532,664,389.80	6,481,999,649.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	697,133,424.80	572,704,165.00
120	Нийтлэг татварын бус орлого	697,133,424.80	572,704,165.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	697,133,424.80	572,704,165.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	671,263,724.80	549,842,115.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,869,700.00	22,862,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,835,530,965.00	5,909,295,484.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,787,853,665.00	5,824,019,484.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,787,853,665.00	5,824,019,484.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,677,300.00	85,276,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,850,000.00	7,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,827,300.00	78,276,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,484,433,134.80	6,445,518,449.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,484,433,134.80	6,445,518,449.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,164,589,029.10	6,044,654,915.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,043,487,363.57	4,827,614,304.29
210101	Үндсэн цалин	2,860,698,430.14	3,367,486,061.31
210102	Нэмэгдэл	954,827,204.38	1,223,059,307.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	151,155,832.90	155,561,526.25
210104	Урамшуулал	76,805,896.15	81,507,409.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	478,374,889.24	594,476,800.00
210201	Тэтгэврийн даатгал	334,582,890.00	443,369,004.91
210202	Тэтгэмжийн даатгал	35,947,999.24	42,132,687.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	28,758,400.00	31,914,599.19
210204	Ажилгүйдлийн даатгал	7,189,600.00	7,456,780.74
210205	Эрүүл мэндийн даатгал	71,896,000.00	69,603,727.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	357,249,497.29	372,518,107.31
210301	Гэрэл, цахилгаан	63,095,552.00	75,903,470.57
210302	Түлш, халаалт	85,571,912.29	97,489,017.58
210303	Цэвэр, бохир ус	43,582,033.00	34,125,619.16
210304	Байрны түрээс	165,000,000.00	165,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,560,327.00	20,754,256.00
210401	Бичиг хэрэг	4,004,600.00	2,544,450.00
210402	Тээвэр, шатахуун	1,108,177.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,152,800.00	12,016,171.71
210404	Ном, хэвлэл	24,043,260.00	490,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,484,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,767,490.00	5,703,634.29

2105	Нормативт зардал	64,285,632.00	58,610,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,508,532.00	689,450.00
210502	Хоол, хүнс	62,244,100.00	57,659,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533,000.00	261,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,447,305.00	33,337,610.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,139,000.00	17,364,000.00
210604	Урсгал засвар	12,308,305.00	15,973,610.00
2107	Томилолт, зочны зардал	-	180,000.00
210702	Дотоод албан томилолт	-	180,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,108,119.00	121,645,238.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,041,071.00	84,470,990.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,500,000.00	20,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	179,548.00	154,048.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,387,500.00	16,520,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,075,896.00	15,517,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,815,900.00	5,022,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,259,996.00	10,495,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	319,844,105.70	400,863,533.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	115,597,468.00	295,113,284.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,086,450.00	71,411,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,787,618.00	223,702,284.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,723,400.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	204,246,637.70	105,750,249.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	197,263,087.70	93,490,415.40
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,983,550.00	12,259,834.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	48,231,255.00	36,481,200.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	46,560,000.00	36,481,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	46,560,000.00	36,481,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	46,560,000.00	36,481,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	46,560,000.00	36,481,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(46,560,000.00)	(36,481,200.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,671,255.00	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,986,740.00	6,657,995.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,657,995.00	6,657,995.00

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(2,225,579,621.69)	10,910,415,921.84
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,010,432,655.62	5,125,562,887.91	(2,225,579,621.69)	10,910,415,921.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	200,494,942.00	-	200,494,942.00
Тайлант үеийн үр дүн	-	-	(435,826,300.49)	(435,826,300.49)
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,326,057,829.91	(2,661,405,922.18)	10,675,084,563.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,010,432,655.62	5,326,057,829.91	(2,661,405,922.18)	10,675,084,563.35
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	281,494,294.89	281,494,294.89
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,010,432,655.62	5,326,057,829.91	(2,379,911,627.29)	10,956,578,858.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,657,995.00	(6,657,995.00)	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,425,918,300.00	6,303,233,233.60	122,685,066.40	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,425,918,300.00	6,303,233,233.60	122,685,066.40	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,123,004,800.00	6,044,769,949.60	78,234,850.40	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,860,038,300.00	4,827,614,304.29	32,423,995.71	99.3
210101	Үндсэн цалин	2,820,632,400.00	3,367,486,061.31	(546,853,661.31)	119.4
210102	Нэмэгдэл	1,717,107,000.00	1,223,059,307.23	494,047,692.77	71.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,190,000.00	155,561,526.25	(75,371,526.25)	194.0
210104	Урамшуулал	242,108,900.00	81,507,409.50	160,601,490.50	33.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	594,476,800.00	594,476,800.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	391,914,300.00	443,369,004.91	(51,454,704.91)	113.1
210202	Тэтгэмжийн даатгал	50,640,600.00	42,132,687.80	8,507,912.20	83.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,512,500.00	31,914,599.19	8,597,900.81	78.8
210204	Ажилгүйдлийн даатгал	10,128,300.00	7,456,780.74	2,671,519.26	73.6
210205	Эрүүл мэндийн даатгал	101,281,100.00	69,603,727.36	31,677,372.64	68.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,970,800.00	372,518,107.31	2,452,692.69	99.3
210301	Гэрэл, цахилгаан	69,712,000.00	75,903,470.57	(6,191,470.57)	108.9
210302	Түлш, халаалт	89,562,500.00	97,489,017.58	(7,926,517.58)	108.9
210303	Цэвэр, бохир ус	18,396,300.00	34,125,619.16	(15,729,319.16)	185.5
210304	Байрны түрээс	197,300,000.00	165,000,000.00	32,300,000.00	83.6
2104	Хангамж, бараа материалын зардал	19,819,300.00	19,819,300.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	748,400.00	2,459,450.00	(1,711,050.00)	328.6
210402	Тээвэр, шатахуун	122,300.00	-	122,300.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,113,300.00	11,666,171.71	447,128.29	96.3
210404	Ном, хэвлэл	885,100.00	490,000.00	395,100.00	55.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,781,100.00	-	1,781,100.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,169,100.00	5,203,678.29	(1,034,578.29)	124.8
2105	Нормативт зардал	95,589,400.00	58,610,650.00	36,978,750.00	61.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	755,100.00	689,450.00	65,650.00	91.3
210502	Хоол, хүнс	94,572,900.00	57,659,800.00	36,913,100.00	61.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	261,400.00	261,400.00	0.00	100.0

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,693,000.00	43,049,600.00	1,643,400.00	96.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,613,600.00	36,970,200.00	1,643,400.00	95.7
210604	Урсгал засвар	6,079,400.00	6,079,400.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	187,200.00	180,000.00	7,200.00	96.2
210702	Дотоод албан томилолт	187,200.00	180,000.00	7,200.00	96.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	120,195,800.00	117,645,238.00	2,550,562.00	97.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,812,000.00	80,470,990.00	341,010.00	99.6
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	20,500,000.00	20,500,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	156,300.00	154,048.00	2,252.00	98.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,727,500.00	16,520,200.00	2,207,300.00	88.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,034,200.00	10,855,950.00	2,178,250.00	83.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,538,800.00	360,550.00	2,178,250.00	14.2
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,495,400.00	10,495,400.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	302,913,500.00	258,463,284.00	44,450,216.00	85.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	302,913,500.00	258,463,284.00	44,450,216.00	85.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,168,400.00	34,761,000.00	6,407,400.00	84.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	261,745,100.00	223,702,284.00	38,042,816.00	85.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,425,918,300.00	6,303,233,233.60	122,685,066.40	98.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,862,062,300.00	5,730,529,068.60	131,533,231.40	97.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,862,062,300.00	5,730,529,068.60	131,533,231.40	97.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	563,856,000.00	572,704,165.00	(8,848,165.00)	101.6
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	541,356,000.00	549,842,115.00	(8,486,115.00)	101.6
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,500,000.00	22,862,050.00	(362,050.00)	101.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,657,995.00	(6,657,995.00)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	245	245	-	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	217	217	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25	25	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		85,276,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		73,016,166.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,366,166.00
2104	Хангамж, бараа материалын зардал		934,956.00
210401	Бичиг хэрэг		85,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		350,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		499,956.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		26,769,210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		16,875,000.00
210604	Урсгал засвар		9,894,210.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		4,662,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,662,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		36,650,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		36,650,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		36,650,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		12,259,834.00
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг		12,259,834.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		85,276,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		85,276,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		78,276,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 96,438.4 мянган төгрөгийн алдаа илэрснээс, аудитын явцад 96,438.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулав.

Аудитаар нийт 36,454.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 34,838.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,616.9 мянган төгрөгийн 7 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 36,454.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 60,044.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланд 448.0 мянган төгрөгийн орлого буруу бүртгэсэн, тайлант үеийн үр дүнг 2500.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн, 93,490.4 мянган төгрөгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохируулга хийгээгүй, орхигдуулсан	1	96,438.4			1	96,438.4	1	96,438.4				
Дүн	1	96,438.4			1	96,438.4	1	96,438.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого явуулсан боловч тооллогын дүнг цаг хугацаанд нь хэлэлцэж шийдвэрлээгүй, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	-					1	-				
2	Тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 1064 нэр төрлийн 809,637.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-				
3	Сургалтын төлбөрийн орлогыг мөнгөн сууриар бүртгэсэн байна.	1	-					1	-				
4	Нэр бүхий 4 байгууллагатай байгуулсан ажил гүйцэтгэх нийт 24,368 мянган төгрөгийн гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, урсгал засварт зарцуулсан 10,047.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.	1	34,838.0			1	34,838.0						
5	Нэр бүхий 33 ажилтныг ээлжийн амралтын хугацаанд анги, танхимын цэвэрлэгээнд 1 өдөр	1	1,616.9					1	1,616.9				

	ажиллуулж, 1,616.9 мянган төгрөгийн цалин олгосон байна.												
6	Гадаад оюутнуудтай байгуулсан гэрээнд сургалтын төлбөрийн мөнгөн дүнг тусгаагүй байна.	1	-					1	-				
7	Найтс Арч ХХК-тай байгуулсан төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний 1.3, 1.5 дахь заалтуудын дагуу сонгон шалгаруулалт хийлгүйгээр гэрээг дахин сунгасан байна.	1	-					1	-				
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2020 оноос хойших холбогдох хууль, тогтоомжийн шинэчлэлтийг тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.	1						1					
	Дүн	8	36,454.9	0	-	1	34,838.0	7	1,616.9				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрснээс 10,348.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдийг улсын дугаарыг цэнхэр дэвсгэртэй дугаараар солиулаагүй байна.	1	-					1	-
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
2	171 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1	10,348.0					1	10,348.0
	Дүн	2	10,348.0					2	10,348.0